

Хаан Хүнс Импекс ХХК

ЧАНАРЫН ГАРЫН АВЛАГА

Код: ХХИ-ЧУТ-ГА

УЛААНБААТАР ХОТ
2023 ОН

Чанарын гарын авлага	Боловсруулсан огноо	Хувилбар
Код: ХХИ-ЧУТ-ГА	2023.10.18	3

БАТАЛГААЖУУЛАЛТ

Оролцоо	Албан тушаал	Нэр	Гарын үсэг	Огноо
Боловсруулсан	Чанарын ахлах менежер	Б.Анхбаяр		
Хянасан	Ерөнхий менежер	Х.Зориг		
Баталсан	Захирал	Г.Чимэд-Очир		

Чанарын гарын авлага	Боловсруулсан огноо	Хувилбар
Код: ХХИ-ЧУТ-ГА	2023.10.18	3

Агуулга

Ерөнхий зүйл:	5
НЭГ. ХАМРАХ ХҮРЭЭ	11
ХОЁР. НОРМАТИВ ИШ ТАТАЛТ.....	11
ГУРАВ. НЭР ТОМЪЁОНЫ ТОДОРХОЙЛОЛТ	12
ДӨРӨВ. БАЙГУУЛЛАГЫН ТӨЛӨВ БАЙДАЛ	16
4.1. Байгууллага болон түүний төлөв байдлыг ойлгох	16
4.2. Сонирхогч талуудын хэрэгцээ шаардлагыг тодорхойлох	17
4.3. Чанарын менежементийн тогтолцооны хамрах хүрээ	18
4.4. Чанарын менежментийн тогтолцоо ба үйл явц	18
ТАВ.МАНЛАЙЛАЛ.....	21
5.1. Манлайлал ба амлалт.....	21
5.2. Чанарын бодлого.....	23
5.3. Байгууллага дахь үүрэг, хариуцлага, эрх мэдэл	26
ЗУРГАА. ТӨЛӨВЛӨЛТ.....	28
6.1. Эрсдэл ба боломжуудыг авч үзэх арга хэмжээ	28
6.2. Чанарын зорилтууд, зорилтод хүрэхэд чиглэсэн төлөвлөлт	31
6.3. Өөрчлөлтийн төлөвлөгөө.....	32
ДОЛОО: ДЭМЖИХ ХЭСЭГ/НӨӨЦ/	34
7.1. Нөөц	34
7.2. Хүний нөөцийн чадамж	40
7.2. Мэдлэг, ойлголт	43
7.4 Холбоо харилцаа.....	43
7.5 Баримтжуулсан мэдээлэл.....	45
НАЙМ. ҮЙЛ АЖИЛЛАГАА.....	46
8.1. Үндсэн үйл ажиллагааны төлөвлөлт ба хяналт	46
8.2. Бүтээгдэхүүн, үйлчилгээнд тавигдах шаардлага	46
8.3. Төлөвлөгөө, хөтөлбөрийн дизайн ба боловсруулалт хийх.....	48

Чанарын гарын авлага	Боловсруулсан огноо	Хувилбар
Код: ХХИ-ЧУТ-ГА	2023.10.18	3

8.4. Гаднаас нийлүүлж буй үйл явц, бүтээгдэхүүн, үйлчилгээний хяналт	49
8.5. Бүтээгдэхүүн үйлдвэрлэл явуулах болон үйлчилгээ үзүүлэх.....	50
8.6. Бүтээгдэхүүн үйлчилгээг гаргаж бэлтгэх.....	52
ЕС.ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮНЭЛГЭЭ	53
9.2. Дотоод аудит.....	54
9.3 Удирдлагын дүн шинжилгээ.....	56
АРАВ. САЙЖРУУЛАЛТ	57
10.3. Үл тохирол ба залруулах арга хэмжээ.....	58
Баримт бичигтэй танилцсан байдал.....	59
Өөрчлөлтийн бүртгэл	60

Чанарын гарын авлага	Боловсруулсан огноо	Хувилбар
Код: ХХИ-ЧУТ-ГА	2023.10.18	3

Ерөнхий зүйл:

Захирлын мэдэгдэл

Би “Хаан Хүнс Импекс” ХХК-ийн үйл ажиллагаанд MNS ISO 9001:2016 чанарын менежментийн тогтолцоо нэвтрүүлэн, гүйцэтгэлийг сайжруулах, тогтвортой хөгжлийн санаачлагын суурь бий болгох стратегийн шийдвэрийг гаргасан. Энэ тогтолцоо нь хэрэглэгч болон хууль, зохицуулалтын шаардлагад нийцсэн бүтээгдэхүүн үйлчилгээг тууштай нийлүүлэх, байгууллагын төлөв байдал, зорилтуудтай холбоотой эрсдэл ба боломжуудыг авч үзэх буюу олон улсын стандартын дагуу үйл ажиллагаа явуулж, хэвшүүлнэ гэж үзсэн.

Сүүлийн 10-н жилийн хугацаанд бид өөрсдийн үйлдвэрлэлийн тогтолцоог тасралтгүй шинэчлэн сайжруулж ирсэн. Иймээс бид Чанарын менежментийн тогтолцооны гарын авлагыг боловсруулан цаашид голлох баримт бичгээ болгон ашиглах болно.

Тус гарын авлагад өнөөдрийг хүртэл даган мөрдөж ирсэн дүрэм, журмыг тоймлон тусгасан ба миний бие тус тогтолцоог нэвтрүүлж, хэрэгжүүлэх гол үүргийг хүлээн, бодлогын түвшинд дэмжиж ажиллана.

Тус гарын авлагад тусгагдсан зорилго, зорилтод хүрэхэд нийт ажилтнуудын хандлага, мэдлэг, ур чадвар, үүрэг оролцоо хамгийн чухал бөгөөд ажилтнууд дараах үүргийг хүлээнэ. Үүнд:

- ЧУТ-ны баримт бичгүүдэд тусгасан үйл ажиллагааг хүндэтгэн үзэж, бүрэн дүүрэн хэрэгжүүлэх;
- Сайжруулах арга хэмжээг хэрэгжүүлэхэд идэвхи зүтгэлтэй оролцох;
- Бизнесийн бүх үйл явцад хамаарах аливаа журам, ажлын арга аргачлалыг тасралтгүй сайжруулах;
- Үүссэн зөрчлийн шалтгаанд дүн шинжилгээ хийж, арилгах зорилгоор ЧУТ хэрэгжүүлэх.

Тус гарын авлагын зорилго нь:

- ЧУТ-г үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж, хэвшүүлэх
- ЧУТ-ны баримтлах бодлогыг түгээх;
- ЧУТ-г шалгахад зориулсан баримт бичгийн сууриар хангах, боловсруулах, шинэчлэх;
- ЧУТ-ны талаар хүлээх үүрэг, хариуцлага, эрх мэдлийг тодорхойлох

Чанарын гарын авлага	Боловсруулсан огноо	Хувилбар
Код: ХХИ-ЧУТ-ГА	2023.10.18	3

- Үйлдвэрлэлд эрүүл, аюулгүй орчин бүрдүүлж өдөр бүр баталгаат бүтээгдэхүүнээр хэрэглэгчдийг хангах, хянах ЧУТ бүрдүүлэх.

Тус гарын авлага нь “Хаан Хүнс Импекс” ХХК-ийн ЧУТ-ны стандартын шаардлагуудад нийцсэн гэдгийг “Хаан Хүнс Импекс” ХХК-ийн дотоод аудитын баг, гэрчилгээ олгогч байгууллагын хөндлөнгийн аудиторууд болон манай бүтээгдэхүүнийг худалдан авагч нарт нотлон харуулсан баримт бичиг юм.

Тус гарын авлага нь ЧУТ-г бий болгож, ажиллуулж, хадгалж, сайжруулахад шаардагдах бүх мэдээллийг “Хаан Хүнс Импекс” ХХК-ийн ажиллагсдад өгөх болно. “Хаан Хүнс Импекс” ХХК-ийн бүх ажилтнууд өөрсдийн хүлээсэн үүрэг, хариуцлагын хүрээнд тус гарын авлагын заалтуудыг үр дүнтэй хэрэгжүүлэх эрх мэдэлтэй. Ажилтан бүр өөрийн гүйцэтгэж буй ажлын чанарыг хариуцах бөгөөд ЧУТ-ны баримт бичгүүдэд тусгасан үйл ажиллагаануудыг гүйцэтгэх үүрэгтэй.

Стандарт хэрэгжүүлэх багийн ахлагч стандарт хэрэгжилтийн талаар Ерөнхий захиралд тогтмол мэдээллэнэ. Бид хамтдаа ЧУТ-ны үр өгөөжтэй байдал, үр дүнд жилдээ дор хаяж нэг удаа үнэлгээ хийж, тус тогтолцоогоо хөгжүүлж, өөрсдийн бизнесийг сайжруулах чиглэлээр ажиллах болно.

Амжилтын төлөө хамтдаа,

“Хаан Хүнс Импекс” ХХК
Захирал
Г.ЧИМЭД ОЧИР

Улаанбаатар хот 2023 оны ... сарын ... өдөр

Чанарын гарын авлага	Боловсруулсан огноо	Хувилбар
Код: ХХИ-ЧУТ-ГА	2023.10.18	3

Хаан хүнс импекс ХХК-ийн Алсын хараа:



Хаан хүнс импекс ХХК-ийн Эрхэм зорилго:



Хаан хүнс импекс ХХК-ийн Уриа:



Чанарын гарын авлага	Боловсруулсан огноо	Хувилбар
Код: ХХИ-ЧУТ-ГА	2023.10.18	3

Бид 2023 оноос Олон улсын Чанарын менежментийн тогтолцоо MNS ISO 9001:2016-г үйл ажиллагаандаа нэвтрүүлэн, шаардлагыг ханган ажиллахаар зорьж байгаа ба ингэснээр дараах ач холбогдолтой. Үүнд:

1. Байгууллагын үйл ажиллагааг алсын хараа, эрхэм зорилго, стратеги зорилтод хүрэхэд илүү сайн чиглүүлэх;
2. Нийгмийн бүх талуудад хүртээмжтэй, чанартай бүтээгдэхүүн үйлчилгээг хүргэх замаар байгууллагын нийгмийн хариуцлагыг дээшлүүлэх;
3. Байгууллагын үр дүнтэй байдал, үр ашгийг харуулах, нэмэгдүүлэхэд чиглэсэн үйл явц ба үнэлгээний хэрэглүүр болох;
4. Байгууллагын нэр хүндийг өргөж, Хэрэглэгчдийн итгэлийг дээшлүүлэх;
5. Сонирхогч талуудын оролцоог нэмэгдүүлэх;
6. Үйл явц, үйл ажиллагааны сайжрал, чанарын соёл бий болох;
7. Ажилтнуудын нөхцөл байдалд тохирсон уян хатан, оновчтой сургалтуудыг явуулах;
8. Олон улс, үндэсний болон бусад боловсролын стандарт, шаардлагуудын уялдааг хангах, тэдэнд нийцэх;
9. Байгууллагын төлөв байдал, зорилтуудтай холбоотой эрсдэл ба боломжуудад чиглэсэн арга хэмжээ авах;
10. Чанарын менежментийн тогтолцооны тогтоосон шаардлагад тохирсон байдлыг харуулах чадвар дээшлэх;

Чанарын гарын авлага	Боловсруулсан огноо	Хувилбар
Код: ХХИ-ЧУТ-ГА	2023.10.18	3


Хаан хүнс имспекс ХХК-ийн ЧУТ-нд дараах 3 арга, хэрэгсэл болох үйл явцын арга, эрсдэлд суурилсан сэтгэлгээг PDCI буюу (Төлөвлө-Гүйцэтгэ-Шалга-Сайжруул) тасралтгүй сайжруулалтын мөчлөгтэй хамт хэрэглэнэ.

1. Үйл явцын арга



1. Эрсдэлд суурилсан сэтгэлгээ


Байгууллагын үйл явц, чанарын удирдлагын тогтолцоог төлөвлөсөн үр дүнгээс хазайхад нөлөөлөх хүчин зүйлсийг тодорхойлох, түүний сөрөг үр дагаварыг бууруулах, бий болсон боломжийг бүрэн ашиглах нөхцлийг бүрдүүлэх, сэргийлэх хяналтыг хэрэгжүүлэх бололцоог олгоно. Төлөвлөсөн үр дүнд хүргэх таатай нөхцөл нь: тухайлбал суралцагч болон бусад үр шим хүртэгчдийг татах, шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ бий болгох, хохирлыг бууруулах, эсвэл бүтээмжийг дээшлүүлэх бололцоо олгож буй байдал нь боломжийг бий болгоно. Эрсдэл нь тодорхой бус байдлын үр дүн ба ийм тодорхой бус байдал нь эерэг ч, сөрөг ч байж болно. Эрсдлээс гарах эерэг өөрчлөлт нь боломж бий болгох боловч эрсдлийн эерэг үр дүн бүр боломж авч ирдэггүй.



Чанарын гарын авлага	Боловсруулсан огноо	Хувилбар
Код: ХХИ-ЧУТ-ГА	2023.10.18	3

2. Тасралтгүй сайжруулах мөчлөг /PDCA/

Тасралтгүй сайжруулах мөчлөг (Төлөвлө-Гүйцэтгэ-Шалга-Сайжруул) буюу PDCA (Plan-Do-Check-Act) нь байгууллагын үйл явцыг хангалтай нөөц, зохих удирдлагаар хангах, мөн сайжруулах боломжийг тодорхойлж, хэрэгжүүлэх бололцоог олгоно. Энэхүү аргыг байгууллагын хэмжээнд хэрэглэнэ. ТАЙЛБАР: Хаалтан дахь тоонууд энэхүү баримт бичгийн бүлгүүдэд хамаарна.



- **Төлөвлө:** Ажилтнууд болон бусад үр шим хүртэгчдийн шаардлага ба байгууллагын зорилгод нийцсэн үр дүнд хүргэхэд шаардлагатай тогтолцооны болон үйл явцын зорилтууд, нөөцийг тогтоох, эрсдэл ба боломжийг тодорхойлох, авч үзэх
- **Гүйцэтгэ:** Төлөвлөснийг хэрэгжүүлэх
- **Шалга:** Үйл явц болон гарах бүтээгдэхүүн, үйлчилгээг бодлого, зорилт, шаардлага болон төлөвлөсөн үр дүнгийн дагуу хянах, хэмжих (боломжтой бол)

Чанарын гарын авлага	Боловсруулсан огноо	Хувилбар
Код: ХХИ-ЧУТ-ГА	2023.10.18	3

- **Сайжруул:** Гүйцэтгэлийг шаардлагатай хэмжээнд хүртэл сайжруулах арга хэмжээ авах

НЭГ. ХАМРАХ ХҮРЭЭ

ХХИ-ийн чанар менежментийн тогтолцооны гарын авлага нь нийт ажилтанд зориулсан гарын авлага, лавлах бөгөөд энэхүү баримт бичгийг ХХИ-ийн бусад бодлого, дүрэм, журам, зааврын баримт бичигтэй хамт уншихад тохиромжтой. Энэхүү баримт бичиг нь ХХИ-ийн чанарын менежментийн тогтолцооны шаардлагыг тодорхойлж, бүтээгдэхүүн, үйлчилгээг хэрэглэгчид болон бусад үр шим хүртэгчдэд хүргэхдээ тэдний хэрэгцээ, хүлээлтийг хангах амлалтыг харуулна. Үүнд:

- Сургах, суралцах, судалгаа шинжилгээ, туршилт хийх замаар мэдлэг чадварыг эзэмших, хөгжүүлэхэд дэмжих чадвартайгаа харуулах;
- Хэрэглэгч болон бусад үр шим хүртэгчдийн шаардлагад тохирох байдлыг хангах, сайжруулах үйл явц бүхий тогтолцоог үр нөлөөтэй хэрэглэх замаар тэдний сэтгэл ханамжийг дээшлүүлэх зорилготой шаардлагыг тогтоосон

ХОЁР. НОРМАТИВ ИШ ТАТАЛТ

Дараах бичиг баримтыг хэсэгчлэн нормативаар эш татсан болно. Үүнд:

2.1. Монгол улсын хууль:

- Монгол улсын үндсэн хууль
- Монгол улсын хүнсний тухай хууль
- Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хууль
- Эрүүл ахуйн тухай хууль
- Аж ахуй нэгжийн орлогын албан татварын тухай хууль
- Байгууллагын нууцын тухай хууль
- Патентийн тухай хууль
- Усны тухай хууль
- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль
- Хаягжуулалтын тухай хууль
- Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хууль
- Хог хаягдлын тухай хууль
- Мал амьтны эрүүл мэндийн тухай хууль
- Зөрчлийн тухай хууль

Чанарын гарын авлага	Боловсруулсан огноо	Хувилбар
Код: ХХИ-ЧУТ-ГА	2023.10.18	3

- Органик хүнсний тухай хууль
- Технологи дамжуулалтын тухай хууль
- Эрүүл мэндийн даатгалын тухай хууль
- Ус бохирдуулсны төлбөрийн тухай хууль
- Нийгмийн даатгалын тухай хууль
- Хөдөлмөрийн тухай хууль
- Хот суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хууль
- Газрын тухай хууль
- Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хууль

- Хувь хүний нууцын тухай хууль

2.2. **Журам:**

- Захиргаа, хүний нөөцийн албаны үйл ажиллагааны журам - ХХИ-ЗХНА-10-01
- Нэмэгдэл цалин, урамшуулал тооцох журам - ХХИ-ЗХНА-10-02
- Шагнал урамшууллын журам - ХХИ-ЗХНА-10-03
- Санхүү хангамжийн албаны үйл ажиллагааны журам - ХХИ-СХА-10-01
- Инженер техникийн албаны үйл ажиллагааны журам - ХХИ-ИТА-10-01
- Чанарын албаны үйл ажиллагааны журам - ХХИ-ЧА-10-01
- ХАБЭА үйл ажиллагааны журам -ХХИ-ХАБ-10-01
- ХАБЭА-н зөвлөлийн үйл ажиллагааны журам -ХХИ-ХАБ-10-02
- ISO 9001:2016 Чанарын менежментийн тогтолцоо- Шаардлага стандарт

ГУРАВ. НЭР ТОМЪЁОНЫ ТОДОРХОЙЛОЛТ

3.1. Чанарын менежментийн тогтолцоо: Хэрэглэгч, ажилтнууд болон бусад үр шим хүртэгчдийн шаардлагыг тогтвортой хангаж, тэдний сэтгэл ханамжийг дээшлүүлэхэд чиглэсэн харилцан хамаарал, үйлчлэл бүхий бодлого, зорилт, үйл явцуудын багц

3.2. Чанарын гарын авлага: Чанарын бодлогыг багтаасан чанарын менежментийн тогтолцооны тайлбар баримт бичиг

3.3. Чанар: Багц үзүүлэлт нь шаардлагыг биелүүлэх хэр хэмжээ

3.4. Шаардлага: Нийтээр зөвшөөрсөн эсвэл гол төлөв мэдээжийн буюу албан журмын шинжтэй тогтоосон хэрэгцээ буюу хүлээлт

3.5. Үйлчилгээ: Хэрэглэгч, сонирхогч талуудын сэтгэл ханамжийг дээшлүүлэхийн тулд байгууллагын хэрэгжүүлж буй үйл ажиллагаа.

Чанарын гарын авлага	Боловсруулсан огноо	Хувилбар
Код: ХХИ-ЧУТ-ГА	2023.10.18	3

3.6. Бүтээгдэхүүн: Хэрэглэгчдийн хэрэгцээ, шаардлагыг хангахын тулд зах зээлд нийлүүлж буй биет болон биет бус хөрөнгө.

3.7. Сургах: Хэрэглэгч, ажилтнууд, сонирхогч талуудын аливаа үйл явцад нь туслах замаар тэдэнтэй хамтарч ажиллах

3.8. Сургалт: Шаардлагыг хангахын тулд мэдлэг, дадлага, чадварыг олгох, хөгжүүлэх үйл явц

3.9. Хөтөлбөр: Дэс дараалал, төлөвлөгөөтэйгөөр юуг, яагаад, яаж, хэр зэрэг сайн суралцах ёстой вэ гэдгийг баримтжуулсан мэдээлэл


3.10. Стратеги: Байгууллагын эрхэм зорилгыг биелүүлэх, байгууллагын алсын хараанд чиглэсэн төлөвлөгөө

3.11. Үйл явц: Төлөвлөсөн үр дүнд хүрэхийн тулд оролтыг гаралт болгон хувиргах харилцан уялдаа, харилцан үйлчлэл бүхий багц үйл ажиллагаа

3.12. Гаралт: Үйл явцын үр дүн

3.13. Байгууллагын төлөв байдал: Байгууллагын зорилтуудыг бий болгох ба түүнийг хангахад нөлөөлж болох дотоод, гадаад асуудлын нэгдэл

3.14. Сонирхогч талууд: Байгууллагын шийдвэр эсвэл үйл ажиллагаанд нөлөөлж болох, нөлөөнд автаж болох эсвэл өөрийгөө нөлөөнд автана гэж төсөөлж буй оролцогч хүн эсвэл байгууллага



Чанарын гарын авлага	Боловсруулсан огноо	Хувилбар
Код: ХХИ-ЧУТ-ГА	2023.10.18	3

- 3.14.1. **Дээд удирдлага:** Захирал, Ерөнхий менежер
- 3.14.2. **Удирдлага:** Ахлах менежер
- 3.14.3. **Хэрэглэгч:** Бүтээгдэхүүн, үйлчилгээний үр шимийг хүртэгч
- 3.14.4. **Гадны нийлүүлэгч:** Байгууллагын үйл ажиллагаа, үйл явцын нэг хэсгийг гүйцэтгэж буй үндсэн орон тооны бус гадны хүн буюу байгууллага
- 3.14.5. **Нийгмийн хариуцлага:** Байгууллагын шийдвэр, үйл ажиллагаа нь нийгэм, хүрээлэн буй орчинд үзүүлэх нөлөөллийг ёс суртахууны хувьд ил тод байлгах нь байгууллагын үүрэг хариуцлага юм. Үүнд:
- 3.14.5.1. Тогтвортой хөгжил, түүний дотор эрүүл мэнд, нийгмийн халамжид хувь нэмэр оруулах
 - 3.14.5.2. Сонирхогч талуудын итгэл найдварыг харгалзан үзэх
 - 3.14.5.3. Холбогдох хууль, олон улсын хэм хэмжээ, зан төлөвт нийцсэн байх
 - 3.14.5.4. Байгууллагын хэмжээнд нэгтгэж, гадаад дотоод харилцаа холбооны хүрээнд хэрэгжүүлэх
- 3.14.6. **Баримтжуулсан мэдээлэл:** Байгууллагаас хяналт тавих, бүрэн бүтэн байлгах, түүний агуулж буй орчинд хяналт тавих шаардлагатай мэдээлэл
- 3.14.7. **Эрсдэл:** Тодорхойгүй байдлын үр нөлөө
- 3.14.8. **Боломж:** Эерэг өөрчлөлт, үр дүн авчирч болохуйц нөхцөл байдал.
- 3.14.9. **Чадамж:** Зорьсон үр дүнд хүрэхийн тулд мэдлэг, ур чадварыг ашиглах чадвар
- 3.14.10. **Чанарын аудит:** Аудитын нотолгоог олж, энэ нь аудитын шалгууртай ямар хэмжээнд нийцэж буйг бодитойгоор тогтоох байнгын, бие даасан, баримтжуулсан үйл явц
- 3.14.11. **Дотоод аудит:** Стандартын шаардлагад нийцэж байгаа болон үл нийцэж буй байдлыг тогтоох баримтжуулсан үйл явц
- 3.14.12. **Гүйцэтгэл:** Хэмжиж болохуйц үр дүн (Гүйцэтгэл нь тоон болон чанарын үр дүнтэй холбоотой болно)
- 3.14.13. **Залруулга:** Гарсан алдаа буюу үл тохирлыг засч сайжруулсан арга хэмжээ
- 3.14.14. **Залруулах арга хэмжээ:** Гарсан алдаа буюу үл тохирлын учир шалтгаан, нөхцөл байдлыг тодорхойлж, дахин гаргахгүй байх арга хэмжээ

Чанарын гарын авлага	Боловсруулсан огноо	Хувилбар
Код: ХХИ-ЧУТ-ГА	2023.10.18	3

3.14.15. **Мониторинг:** Үйл ажиллагааг хянах, ажиглах, таамаглалын үнэлэлт өгөх, зөвлөмж боловсруулах үүднээс тогтмол мэдээлэл авах зорилготой үйл ажиллагаа

3.14.16. **Дүн шинжилгээ:** Тогтоосон зорилгод хүрэхэд хэр тохиромжтой, хангалттай бөгөөд үр нөлөөтэй болохыг тодорхойлохын тулд тоон мэдээлэл дээр үндэслэн явуулах үйл ажиллагаа

3.14.17. **Үр нөлөө:** Төлөвлөсөн үйл ажиллагааны хэрэгжилт, үр дүнд хүрсэн байдлын хэмжээ

3.14.18. **Батлах:** Тодорхой зориулсан хэрэгцээ буюу ашиглалтын шаардлага биелсэн болохыг бодит баримт гаргах замаар нотлох үйл явц

3.14.19. **Хүртээмжтэй байдал:** Хамгийн өргөн хүрээний боломж бүхий хүмүүсийн бүтээгдэхүүн, үйлчилгээ, орчин, төхөөрөмжийн тухтай хэрэглээ

3.14.20. **Тасралтгүй сайжруулалт:** Гүйцэтгэлийг сайжруулах дахин давтагдах үйл ажиллагаа

Товчилсон үгсийн тайлбар:


- ХХИ - Хаан хүнс импекс ХХК
- ЧУТ - Чанарын удирдлагын тогтолцоо
- ДА - Дотоод аудит
- ЧА - Чанарын алба
- ХАБ - Хөдөлмөр, аюулгүй байдал

Чанарын гарын авлага	Боловсруулсан огноо	Хувилбар
Код: ХХИ-ЧУТ-ГА	2023.10.18	3

ДӨРӨВ. БАЙГУУЛЛАГЫН ТӨЛӨВ БАЙДАЛ

4.1. Байгууллага болон түүний төлөв байдлыг ойлгох

ХХИ нь удирдлагын тогтолцооны хүрээнд зорьсон үр дүнд хүрэх, зорилтоо хэрэгжүүлэх боломж, стратеги чиглэлд хамааралтай гадаад, дотоод орчны асуудлыг тодорхойлж, эдгээр асуудалд дүн шинжилгээ хийхдээ SWOT шинжилгээний аргыг хэрэглэдэг. SWOT шинжилгээ нь байгууллагын дотоод орчны давуу, сул тал болон гадаад орчин (макро ба микро)-ы боломж, эрсдэл аюулын тодорхойлолтоос бүрдэнэ. Байгууллагын стратеги төлөвлөлтийг хийх, үнэлэх үйл явц нь:



Стратеги төлөвлөгөөний гүйцэтгэлд жил бүр хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, хэрэгжилтийг эрчимжүүлэх арга хэмжээ авна. Үнэлгээнд үндэслэн тухайн жилийн зорилтот түвшинд хүрч чадаагүй үйл ажиллагааны гүйцэтгэлийг

Чанарын гарын авлага	Боловсруулсан огноо	Хувилбар
Код: ХХИ-ЧУТ-ГА	2023.10.18	3

сайжруулах, алдаа дутагдлыг арилгах арга хэмжээг төлөвлөн, дараа жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгана.

ХОЛБОГДОХ БАРИМТЖУУЛСАН МЭДЭЭЛЭЛ:

- SWOT шинжилгээ – ХХИ-ЧУТ-4.1-Ши

4.2. Сонирхогч талуудын хэрэгцээ шаардлагыг тодорхойлох

ХХИ нь бүтээгдэхүүн үйлчилгээгээ хууль тогтоомж, зохицуулалтын шаардлагын дагуу тасралтгүй үзүүлэх, тогтвортой амжилтанд хүрэхийн тулд өөрийн ЧУТ-нд хамаарах сонирхогч талуудыг дараах загварын дагуу тодорхойлж, төлөвлөгөө гарган ажиллана.

Бид сонирхогч талуудын хэрэгцээ ба хүлээлтийг хангахад байнга анхаарч, төвлөрч ажиллана. Тэдний хэрэгцээ хүлээлтийн хангагдаж буй байдлын талаар мэдэж болох үзүүлэлтүүдээс дурдвал:

- Үйл ажиллагааны тайлан, үр дүн
- Санхүүгийн тайлан
- Гүйцэтгэлийн үнэлгээ
- Борлуулалтын тоо хэмжээ
- Судалгааны үр дүн
- Сэтгэл ханамжийн судалгааны үр дүн
- Ирүүлсэн өргөдөл, санал, гомдлын байдал

ХОЛБОГДОХ БАРИМТЖУУЛСАН МЭДЭЭЛЭЛ:

1. Бизнес төлөвлөгөөний гүйцэтгэл
2. Сарын тайлан
3. 7 хоногийн мэдээ
4. Санхүүгийн тайлан
5. Өргөдлийн бүртгэл
6. Үл тохирлын бүртгэл

Чанарын гарын авлага	Боловсруулсан огноо	Хувилбар
Код: ХХИ-ЧУТ-ГА	2023.10.18	3

4.3. Чанарын менежементийн тогтолцооны хамрах хүрээ

ХХИ нь дараах үйл явцад чанарын менежментийн тогтолцоог нэвтрүүлж байна.

Үүнд:


Хиам, хагас боловсруулсан мах, махан бүтээгдэхүүн үйлдвэрлэл, борлуулалт, түгээлт

4.4. Чанарын менежментийн тогтолцоо ба үйл явц

ХХИ нь өөрийн ЧУТ-нд шаардагдах харилцан уялдаатай үйл явцуудыг тодорхойлж, хэрэгжүүлэн, тасралтгүй сайжруулна. Бид олон улсын стандартын шаардлагад нийцүүлэн үйл явцыг баримтжуулсан мэдээлэл хэлбэрээр хадгалж, хэрэглэнэ. Доорх үйл явцууд нь хамтран ажиллаж байж сонирхогч талуудын хэрэгцээ, шаардлагыг тэдний сэтгэл ханамж болгон хувиргана.

Чанарын гарын авлага	Боловсруулсан огноо	Хувилбар
Код: ХХИ-ЧУТ-ГА	2023.10.18	3

ХХИ-ийн үйл явцын загвар



Чанарын гарын авлага	Боловсруулсан огноо	Хувилбар
Код: ХХИ-ЧУТ-ГА	2023.10.18	3

Менежментийн үйл явц: ХХИ-ийн ажил олгогч, ажилтнууд байгууллагын алсын хараа, эрхэм зорилго, стратеги зорилгод хүрэхийн тулд чанарын менежментийн арга хэрэгслийг ашиглана. Энд үйл ажиллагааны чиглэл, зорилго, төлөвлөгөөг тодорхойлж, хүссэн үр дүнд хүрэхийн тулд удирдах, зохион байгуулах, хянах, үнэлэх, сайжруулах үйл явцууд багтана.

Үндсэн үйл явц: Ажилтан болон бусад сонирхогч талуудын хэрэгцээ, шаардлагыг хангахад чиглэсэн, бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгож буй үндсэн үйл ажиллагаа юм.

Дэмжих үйл явц: Байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг хэвийн, тасалдалгүй явуулахад шаардлагатай нөөц болон өгөгдөл мэдээллээр хангах үндсэн үйл явцын гүйцэтгэлийг дээшлүүлэхэд шаардлагатай үйл ажиллагаанууд юм.

Гаднаас нийлүүлж байгаа үйл явц: Гадны нийлүүлэгч, харилцагчаас авч байгаа бүтээгдэхүүн, үйлчилгээ, үйл явц юм.

ХОЛБОГДОХ БАРИМТЖУУЛСАН МЭДЭЭЛЭЛ:

- Үйл явцын зураглалууд – ХХИ-10-ПЗ

Чанарын гарын авлага	Боловсруулсан огноо	Хувилбар
Код: ХХИ-ЧУТ-ГА	2023.10.18	3

ТАВ.МАНЛАЙЛАЛ

5.1. Манлайлал ба амлалт

ХХИ-ийн Захирал нь ЧУТ-г нэвтрүүлж, хэрэгжүүлэх, боловсронгуй болгох чиглэлээр тууштай байр суурь баримтлах ба хүчин чармайлт гаргаж, анхаарч ажиллана.

5.1.1. ХХИ-ийн Захирлын амлалт:

Байгууллагын алсын хараа, эрхэм зорилго, бодлого болон чанарын зорилтуудыг тодорхойлох, үйлдвэрлэл үйлчилгээний бусад үзэл баримтлалыг тогтвортой хэрэгжүүлэхийг дэмжинэ.

- Холбогдох хууль тогтоомж, зохицуулалтын шаардлагыг тодорхойлж, хангана.
- ЧУТ-ны үр нөлөөтэй байдлыг бүхэлд нь хариуцна.
- Стратеги төлөвлөгөөг боловсруулж, хөгжүүлж, хадгална.
- ЧУТ-ны шаардлагыг байгууллагын бизнес үйл явцтай нийцүүлж нэгтгэх нөхцлөөр хангана.
- Үйл явцын арга, эрсдэлд суурилсан сэтгэлгээг дэмжинэ.
- ЧУТ-нд шаардлагатай нөөцөөр хангана.
- Байгууллагын төлөвлөсөн үр дүнд хүрэх нөхцлийг бүрдүүлнэ.
- ЧУТ-г үр нөлөөтэй байлгахын тулд ажилтнуудын оролцоог ханган чиглүүлж, дэмжлэг үзүүлнэ.
- Тасралтгүй сайжруулалтыг дэмжиж, урамшуулна.
- ХХИ-ийн стратеги төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлэн, хадгална.

5.1.2. Ажилтнуудын боловсролын шаардлага , түүний дотор тусгай хэрэгцээг тодорхойлж, хангана.

5.1.2.1. Нийгмийн хариуцлагын зарчмыг авч үзнэ.

5.1.2.2. Дээд удирдлага нь ажилтнууд болон бусад үр шим хүртэгчдэд төвлөрч ажиллана. Энэ хүрээнд:

- Холбогдох хууль тогтоомж, зохицуулалтын шаардлагыг тодорхойлж, хангана.
- Ажилтнууд болон бусад үр шим хүртэгчдийн хэрэгцээ, хүлээлтийг тодорхойлж, ойлгож, тууштайгаар тэдний сэтгэл ханамжийг дээшлүүлнэ.
- Сургалт, судалгааны үйл ажиллагаанаас ажилтнууд болон бусад үр шим хүртэгчдийн сэтгэл ханамжийг дээшлүүлэхэд нөлөөлөхүйц эрсдэл болон боломжийг тодорхойлж, хэрэгжүүлнэ.

Чанарын гарын авлага	Боловсруулсан огноо	Хувилбар
Код: ХХИ-ЧУТ-ГА	2023.10.18	3

ХОЛБОГДОХ БАРИМТЖУУЛСАН МЭДЭЭЛЭЛ:

- Хөдөлмөрийн дотоод журам- ХХИ-ЗХНА-10-06
- Захиргаа хүний нөөцийн үйл ажиллагааны журам – ХХИ-ЗХНА-10-01
- Нэмэгдэл цалин урамшууллын журам - ХХИ-ЗХНА-10-02
- Шагнал урамшууллын журам – ХХИ-ЗХНА-10-03

Чанарын гарын авлага	Боловсруулсан огноо	Хувилбар
Код: ХХИ-ЧУТ-ГА	2023.10.18	3

5.2. Чанарын бодлого

“Хаан Хүнс Импекс” ХХК бүтээгдэхүүний аюулгүй байдал, чанарыг өндөр түвшинд ханган, хэрэглэгчдийн талархлыг хүртсэн мах, махан бүтээгдэхүүний үйлдвэрлэгч байх. Бид зорилгодоо хүрэхийн тулд дараах зүйлсийг хэрэгжүүлнэ. Үүнд:

- Хэрэглэгчдийн шаардлагад нийцсэн үйлдвэрлэл, үйлчилгээг Монгол улсын хууль, эрх зүйн зохицуулалт, стандарт болон олон улсын стандартын дагуу гүйцэтгэж, орчин үеийн дэвшилтэт техник, технологи ашиглан, байнгын сайжруулж ажиллах;
- Үйлдвэрийн хэрэгцээт түүхий эдийг баталгаат бэлтгэн нийлүүлэгчээс бэлтгэн нийлүүлж хэрэглэгчдийн хэрэгцээ, шаардлага, хүлээлтэнд бүрэн нийцсэн, хүнсний аюулгүй байдал, чанарын шаардлага хангасан бүтээгдэхүүн үйлчилгээг хэрэглэгчдэд борлуулалт түгээлтийн бүрэн тоноглогдсон тээврийн хэрэгслээр хүргэх;
- Хүний нөөцийг тогтвортой байлгаж, чадавхийг нэмэгдүүлэх, тоног төхөөрөмж, технологийн шинэчлэлийг байнга эрэлхийлж түүнд чиглэсэн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэн бүтээгдэхүүний чанарыг сайжруулж, зах зээлд эзлэх байр сууриа бататган салбартаа манлайлах бодлого баримтлан ажиллах;
- Хүрээлэн буй байгаль орчноо хайрлан хамгаалж, байгальд ээлтэй үйлдвэрлэгч байх;

Чанарын зарчим:

1. Хэрэглэгч, сонирхогч талууд болон ажил олгогч, ажилтнуудын хүлээлт ба хэрэгцээнд төвлөрнө.
2. ХХИ-ийн бүх шатны нэгж дэх манлайлагчийн үнэт зүйл, загварыг бий болгож, хэвшүүлнэ.
3. Байгууллагын чанарын менежментийн тогтолцоонд хүн бүрийг оролцуулж, тэдний чадамжийг хөгжүүлнэ.
4. Үйл ажиллагааг ойлгомжтой, харилцан уялдаатай (дэс дараалал) болгоход үйл явцын арга, хандлагыг ашиглана.
5. Гүйцэтгэлийг хянаж, тасралтгүй сайжруулна.
6. Өгөгдөл, мэдээллийн дүн шинжилгээнд үндэслэн шийдвэр гаргана.
7. Харилцан ашигтай хамтын ажиллагааг эрхэмлэнэ.

Чанарын гарын авлага	Боловсруулсан огноо	Хувилбар
Код: ХХИ-ЧУТ-ГА	2023.10.18	3

8. Нийгмийн өмнө хариуцлагатай байна.
9. Бүтээгдэхүүн үйлчилгээг эрх тэгш, хүртээмжтэй хүргэнэ.
10. Мэдээллийн аюулгүй байдал, хамгаалалтыг хангана.

5.2.2. Чанарын бодлогыг байгууллагын хэмжээнд мэдээллэж ойлгуулах, сонирхогч талуудад боломжит хэмжээнд хүртээмжтэй байлгахад анхаарч ажиллана. Мэдээллийн сувгууд:

- ХХИ-ийн вэб сайт <https://khaankhunsimpex.mn/>
- ХХИ-ийн Фэйсбүүк хуудас <https://www.facebook.com/KhaanKhunsImpex/>
- ХХИ-ийн мэйл хаяг: sv@khaankhunsimpex.mn
- Дээд удирдлагын шийдвэрээр батлагдсан тушаал, дүрэм, журам болон бусад баримт бичиг, мэдээллийн самбар
- Сонин, сэтгүүл, брошюре, каталог болон бусад олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, сүлжээ

Чанарын зорилт

“Хаан Хүнс Импекс” ХХК-ийн Захирал байгууллагын Алсын хараа, Эрхэм зорилго, Хүнсний аюулгүй байдлын бодлоготой нийцэмжтэй чанарын зорилтуудыг тодорхойлно. Зорилтуудыг тоон үзүүлэлтүүдээр гаргасан байна. Хэмжигдэхүйц тоон үзүүлэлтүүдээр зорилтуудыг гаргахдаа өмнөх жилийн үр дүн болон ирээдүйн чиг хандлагад үндэслэн гаргана.

Чанарын зорилтуудыг бүх ажиллагсдад мэдээлнэ.

“Хаан Хүнс Импекс” ХХК-ийн хэмжээнд тодорхойлсон чанарын зорилтуудад үндэслэн үйл явцын эзэмшигчид өөрсдийн хариуцсан үйл явцын чанарын зорилтууд болон тэдгээрийг биелүүлэхэд шаардагдах нөөц, арга хэмжээнүүдийг тодорхойлж гаргана.

Удирдлагын зүгээс чанарын зорилтуудын хэрэгжилтийг хүнсний аюулгүй байдал, чанарын удирдлагын тогтолцоонд хийх дүн шинжилгээнийхээ нэг хэсэг болгон улирал тутамд эргэн хянана.

ХОЛБОГДОХ БАРИМТЖУУЛСАН МЭДЭЭЛЭЛ:

- Хаан Хүнс Импекс ХХК-н 2023 оны чанарын зорилго, зорилт - ХХИ-ЧУТ-5.2-3о

Чанарын гарын авлага	Боловсруулсан огноо	Хувилбар
Код: ХХИ-ЧУТ-ГА	2023.10.18	3

Чанарын гарын авлага	Боловсруулсан огноо	Хувилбар
Код: ХХИ-ЧУТ-ГА	2023.10.18	3

5.2.2. Чанарын менежментийн тогтолцоон дахь чиг үүрэг

Чанар хариуцсан нэгж

- ХХИ-ийн олон талт үйл ажиллагаанд холбогдох эрх зүйн акт, стратеги төлөвлөгөөний хэрэгжилт, гүйцэтгэлд хяналт шинжилгээ, үнэлгээ хийнэ.
- ХХИ-ийн Чанарын менежментийн тогтолцооны нэгдмэл байдал, тасралтгүй сайжруулалтыг хангах үйл явцын урсгалыг хянаж, нэгтгэнэ.
- Хэрэглэгч болон бусад үр шим хүртэгчдийн хэрэгцээ ба хүлээлтийг хангахад анхаарч, тэдний мэдээллийг байнга шинэчилнэ.
- Чанарын менежментийн тогтолцооны олон улсын стандартыг туршин нэвтрүүлж, шаардлагад нийцүүлэх үйл ажиллагааг зохион байгуулна.
- Гадаад, дотоод ЧУТ-ны аудитыг зохион байгуулах ажлыг хариуцна.
- Бүтээгдэхүүн, үйлчилгээний нийцэлд нөлөөлөх эрсдэл, боломжийг удирдана
- Чанарын менежментийн тогтолцооны гүйцэтгэл болон сайжруулах боломжуудын тухай дээд удирдлагад тайлагнана.
- Байгууллагын шинээр болон сайжруулан гаргах бодлогын баримт бичгийг боловсруулахад мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, хянана.
- Чанарын соёлыг нийт багш ажилтан, суралцагчдад түгээж, сургалт, сурталчилгаа хийнэ.
- ХХИ-ийн чанарын бодлогыг байгууллагын хэмжээнд мэдээлж ойлгуулах, сонирхогч талуудад боломжит хэмжээнд хүртээмжтэй байлгана.

Нийт ажилтан

- Хариуцсан ажил, үүргийг ЧУТ-ны олон улсын стандартын шаардлагад нийцүүлж ажиллах ба өөрт шаардлагатай чадамжийг тасралтгүй хөгжүүлнэ.
- Стандартаас санал болгосон арга хэрэгслүүд болох үйл явцын арга, PDCA тасралтгүй сайжруулалтын мөчлөг, эрсдэлд суурилсан сэтгэлгээг ойлгож, бүх шатанд хэрэглэнэ.
- ЧУТ-ны гүйцэтгэл, сайжруулах боломжийн талаар дээд удирдлага болон чанар хариуцсан нэгжид тайлагнана.
- Хэрэглэгч болон бусад үр шим хүртэгчдэд төвлөрч, тэдний хэрэгцээ ба хүлээлтийг хангахыг зорьж ажиллах ба бусад сонирхогч талуудад боломжоороо хүртээмжтэй байна.

Чанарын гарын авлага	Боловсруулсан огноо	Хувилбар
Код: ХХИ-ЧУТ-ГА	2023.10.18	3

- Бүтээгдэхүүн, үйлчилгээний чанарыг эрхэмлэж, чанарын гүйцэтгэлд хариуцлага хүлээнэ.
- Аливаа үл тохирлыг мэдээлж, авсан арга хэмжээг тайлагнана.
- Байгууллагын нийгмийн хариуцлагын бодлого, төлөвлөгөөг хэрэгжүүлж, мэдээлэл солилцоог дэмжиж ажиллана.
- Байгууллагын гадаад, дотоод харилцаа холбоог шуурхай, хариуцлагатай зохион байгуулна.
- ХХИ-ийн чанарын бодлого, зорилттой уялдуулан харьяа нэгжийн чанарын зорилтыг тодорхойлж, хэрэгжүүлнэ.
- Ажиллах орчныг тусгай хэрэгцээт болон хөгжлийн бэрхшээлтэй ажилтны шаардлагыг тодорхойлж, хангана.
- Байгууллагад учирч болзошгүй эрсдлийг бууруулах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

ХОЛБОГДОХ БАРИМТЖУУЛСАН МЭДЭЭЛЭЛ:

- Ажлын байрны тодорхойлолт
- Хөдөлмөрийн гэрээ
- Хөдөлмөрийн дотоод журам- ХХИ-ЗХНА-10-06

ЗУРГАА. ТӨЛӨВЛӨЛТ

6.1. Эрсдэл ба боломжуудыг авч үзэх арга хэмжээ

ХХИ нь үйл явцын гүйцэтгэл, бүтээгдэхүүн, үйлчилгээний чанарыг тасралтгүй сайжруулах зорилгоор эрсдэл, боломжуудыг авч үзнэ. Энэхүү гарын авлага болоод холбогдох журмууд нь уг хандлага, аргыг хэрэглэж ирсэн болно. Мөн эрсдэл болон боломжид чиглэсэн арга хэмжээг ЧУТ-ны дотоод аудитын үед төлөвлөн, хэрэгжүүлнэ. Үүнд:

- 6.1.1. Эрсдэлд суурилсан сэтгэлгээг хэрэглэнэ.
- 6.1.2. Үйл явцын алхам тус бүрээр болзошгүй эрсдэл, боломжийг илрүүлж, тодорхойлно.
- 6.1.3. Эрсдэлийг дараах матрицаар үнэлнэ. Эрсдэлийн үнэлгээний матриц:

Чанарын гарын авлага	Боловсруулсан огноо	Хувилбар
Код: ХХИ-ЧУТ-ГА	2023.10.18	3

№	Процессын алхам	Тодорхойлсон үйл явцын алхам бүрийг жагсаан бичнэ.	
1	Гарч болох эрсдлүүд	Тухайн алхамтай холбоотой гарч байсан болон гарч болох эрсдлүүдийг жагсаан бичнэ.	
2	Эрсдлийн үр нөлөө	Эрсдлээс бий болж байсан болон бий болох магадлалтай нөлөөллийг бичнэ.	
3	Эрсдэл үүсэх шалтгаан	Тухайн эрсдлүүд юунаас үүдэн гарч байсан болон гарч болох шалтгааныг тодорхойлон бичнэ.	
4	Хохирол	1	Эрсдэл бага Ноцтой байдал маш бага, бараг сөрөг нөлөөгүй. Тухайн алдааг засахад л хангалттай.
		2	Дунд эрсдэл Санхүүгийн хохиролтой, үйл ажиллагаа тасалдах, эд хөрөнгө эвдрэх, дутах, авлага нэмэгдэх, өр төлбөр хуримтлагдах, төлөвлөгөөний гүйцэтгэл алдагдах
		3	Ноцтой эрсдэл Тухайн ажлын буруу/дутуу үр дүнгээс болж компани буюу групп компани тэр чигтээ хохирол амсах, үйл ажиллагаа доголдох, байгууллагын нэр хүнд ба зах зээлийн үнэлгээ унах, ажлын тусгай зөвшөөрөл ба гэрээ саатах, доголдох, цуцлагдах хүртэл эрсдэлтэй.
5	Магадлал	1	Бага/Жилд 0-2/ Тохиолдох боломж маш бага /маш онцгой байдлаар тохиолдож
		2	Дунд /Жилд 3-6/ Заримдаа гардаг, гарах магадлалтай эрсдэл. Хэзээ гарах нь тодорхойгүй ч урьд нь тохиолдож байсан учраас анхааралдаа байлгаж эрсдлийг удирдах төлөвлөгөөнд оруулна.
		3	Өндөр /Жилд 6-аас дээш/ Байнга гардаг, бодитой байгаа ноцтой эрсдэл. Онцгойлон анхаарах шаардлагатай ба ноцтой эрсдэлийг бууруулах хавсралт төлөвлөгөөнд оруулж байнгын хяналтанд авна.
6	Эрсдлийн зэрэг	1-3	Бага нөлөөлөлтэй Ажлыг үргэлжлүүлэх боломжтой. Эрсдлийн төлөвлөгөө гаргахгүй байж болно.
		4-6	Дунд нөлөөлөлтэй Эрсдлийн төлөвлөгөө гаргаж ажиллана. Давтан сургах, хяналтыг сайжруулах, эрсдэл оршин байгаа нөхцөлд яаралтай засаж, залруулах арга хэмжээ авч ажиллана.
		7-9	Өндөр нөлөөлөлтэй Ажлыг зогсоож, аюулыг арилгасны дараа ажлаа эхлүүлэх, хариу арга хэмжээг хэрэгжүүлсний дараа ажлаа үргэлжлүүлнэ. Эрсдлийн арилгаагүй тохиолдолд ажиллахыг хориглоно.
7	Одоогийн байдал	Одоогийн байдалд тухайн эрсдэл байгаа эсэх, эрсдлийг бууруулах, урьдчилан сэргийлэх, хянах арга хэмжээ авагддаг эсэх	
8	Сайжруулах ажил	4-6 болон 7-9 үнэлгээтэй эрсдлийг бууруулах, арилгах төлөвлөгөөг бичнэ. 7-9 буюу өндөр нөлөөлөлтэй байгаа эрсдлийг яаралтай бууруулах ажил хийхээр төлөвлөнө.	
9	Хариуцах хүн	Тухайн сайжруулах ажлыг гүйцэтгэх ажилтан болон албан тушаалтан	
10	Хамтрах ажилтан	Тухайн сайжруулах ажлыг гүйцэтгэхэд хамтран ажиллах ажилтан болон албан тушаалтан	
11	Хугацаа	Тухайн сайжруулах ажлыг гүйцэтгэхэд хугацааг сараар тодорхойлох. /2022.08 сар гм/ Цаашид сарын ажлын төлөвлөгөөнд тусган ажиллана.	
12	Хэрэгжүүлсэн үйл ажиллагаа	Оны сүүлд төлөвлөсөн ажлын дагуу гүйцэтгэл болон тайлан /тайлбар зураг бүхий/	

6.1.4. Эрсдэлээс сэргийлэх, боломжийг олж авах хариу арга хэмжээг авч, холбогдох үйл явцын өөрчлөлтийг төлөвлөж, хэрэгжүүлнэ.

Арга хэмжээнүүд нь:

1. Эрсдэлийн эх үүсвэрийг арилгах
2. Эрсдэлийн хүлээн зөвшөөрөх
3. Эрсдэл үүсгэгчийг өөр зүйлээр орлуулах, зайлсхийх
4. Эрсдлийг хуваалцах
5. Бусдад шилжүүлэх
6. Нөлөөллийг зөвшөөрөх хэмжээнд хүргэж, тогтоон барих
7. Боломж хайхын тулд эрсдэл хийх гэх мэт

6.1.5. Эрсдэл, боломжийг бүртгэж, сан бүрдүүлэх

6.1.6. Авсан арга хэмжээний үр нөлөөг үнэлнэ.

Чанарын гарын авлага	Боловсруулсан огноо	Хувилбар
Код: ХХИ-ЧУТ-ГА	2023.10.18	3

Чанарын гарын авлага	Боловсруулсан огноо	Хувилбар
Код: ХХИ-ЧУТ-ГА	2023.10.18	3

ХОЛБОГДОХ БАРИМТЖУУЛСАН МЭДЭЭЛЭЛ:

- Эрсдлийн үнэлгээ ХХИ-10-ПЗ-ЭҮ


6.2. Чанарын зорилтууд, зорилтод хүрэхэд чиглэсэн төлөвлөлт

ХХИ-ийн чанарын зорилтууд, түүнд хүрэхэд чиглэсэн төлөвлөгөөг 1 жил тутам үнэлж, сайжруулж ХХИ-ийн Захирлын тушаалаар батлан мөрдөнө. Чанарын зорилт нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

1. Байгууллагын стратеги төлөвлөгөөтэй уялдсан байх
2. Чанарын бодлоготой уялдсан байх
3. Хэмжигдэхүйц байх
4. Байгууллагын үйл ажиллагаатай хамаарах шаардлагыг авч үзсэн буюу хэрэгжихүйц, бодитой байх
5. Үр шим хүртэгчдийн сэтгэл ханамжийг дээшлүүлэхтэй холбоотой байх
6. Хянагддаг байх
7. Чанарын зорилтыг хэрэгжүүлдэг байх
8. Дээд удирдлага, ажилтнуудад мэдээлдэг байх
9. Шаардлагатай тохиолдолд шинэчилдэг байх

Чанарын зорилтууд нь байгууллагын чанарын бодлогыг хэрэгжүүлж, тасралтгүй сайжруулахад чиглэгдэх тул удирдлагын болон үйл ажиллагааны түвшинд сайжруулалт хийх, хэмжигдэхүйц, биелэгдэх боломжтой зорилтуудыг дараах маягтын дагуу өмнөх жилийн 12-р сарын 25-наас өмнө тодорхойлж, Ерөнхий менежерээр батлуулна. Үүнд:

ХХИ-ЧУТ-6.2




Хаан Хүнс Импекс ХХК-н 2023 оны чанарын зорилго, зорилт

Байгууллагын 2023 оны чанарын зорилго					
№	Зорилго	Зорилт	Гарц	Хугацаа	Гүйцэтгэл
1					
2					

Чанарын гарын авлага	Боловсруулсан огноо	Хувилбар
Код: ХХИ-ЧУТ-ГА	2023.10.18	3

Чанарын уялдаа холбоо:



ХОЛБОГДОХ БАРИМТЖУУЛСАН МЭДЭЭЛЭЛ:

- Хаан Хүнс Импекс ХХК-н 2023 оны чанарын зорилго, зорилт- ХХИ-ЧУТ-6.2

6.3. Өөрчлөлтийн төлөвлөгөө

ХХИ нь менежментийн тогтолцоо, үйл ажиллагаанд өөрчлөлт оруулах шаардлагатай гэж тодорхойлсон тохиолдолд өөрчлөлтийг хийхдээ дараахыг авч үзнэ. Үүнд:

